



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/125

Булган сум

“Дэд бүтцийн сэргэлт” хөтөлбөрийн ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 66 дугаар зүйлийн 66.1, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 2.4.3 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 483 дугаар тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт” хөтөлбөрийг батлах тухай IV/25 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралтын 3.2.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Дэд бүтцийн сэргэлт” хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. “Дэд бүтцийн сэргэлт” хөтөлбөр боловсруулахад эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог хангаж, улсын болон аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан салбар дундын бодлогын уялдааг хангаж, хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний хамт боловсруулж, 2 дугаар улиралд багтаан Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулахыг ажлын хэсэг (О.Ундрах)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР





Аймгийн Засаг даргын 20-дугаар сарын 19-ны/ний өдрийн 19-дүгээр захирамжийн хавсралт

“Дэд бүтцийн сэргэлт” хөтөлбөр боловсруулах
ажлын хэсгийн бүрэлдэхүүн

- Ажлын хэсгийн дарга: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)
- Гишүүд:
- М.Цэрэнчимэд (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн бөгөөд аймгийн Ерөнхий архитектор)
 - Г.Нарангэрэл (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
 - Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)
 - Б.Ганзориг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)
 - Б.Ганчулуун (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)
 - Г.Батцагаан (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн)
 - Э.Нямсүрэн (“Булган Мээж” ОНӨХХК-ийн Ерөнхий инженер)
 - Г.Отгонбаяр (“ЭБЦТС” ТӨХК-ийн Булган салбарын дарга)
 - Д.Ням-Осор (“Мэдээлэл холбоо сүлжээ” ХХК-ийн Булган аймаг дахь газрын Ерөнхий инженер)
 - Э.Ууганбаяр (“Долоон бар” ХХК-ийн ерөнхий инженер)
 - Г.Ганзориг (Булган аймгийн “Барилгачдын холбоо”-ны тэргүүн, “Хурмастын хүлэг” ХХК-ийн захирал)
 - Сумын дулаан, усан хангамжийн хангагч байгууллагын захирал
- Нарийн бичгийн дарга: Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)